

ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

Б.Уламбаяр
2024 оны 1 дүгээр улирал



МЭДЭГДЭЛ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Хараат бус гишүүн **Б.Уламбаяр** миний бие: (i) Компанийн тухай хууль (“КтХ”), Банкны тухай хууль (“БтХ”); (ii) Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам” (“Засаглалын хяналт шалгалтын журам”), “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Хараат бус гишүүний журам”); (iii) ХасБанкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан (“Тайлан”)-г бэлтгэсэн болно.

Тайлан нь дараах хугацааг хамарна: 2024 оны 1 дүгээр улирал (“Тайлант хугацаа”).

1.ОРОЛЦООНЫ ТАЙЛАГНАЛ

(Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 болон 5.2.2 дахь заалт)

Тайлант хугацаанд Хүснэгт 1-д заасан дараах хурлуудад оролцож ажиллалаа.

Тайлант хугацаан дахь ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Хороодын хурлууд

Хүснэгт 1

Хурлууд	Оролцсон байдал	Огноо
ТУЗ-ийн хурал	Хараат бус гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2024 оны 2 дугаар сарын 02-05 2024 оны 2 дугаар сарын 19 2024 оны 3 дугаар сарын 06-07 2024 оны 3 дугаар сарын 12-15
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал (“АХ”)	Хорооны даргаар	<ul style="list-style-type: none"> 2024 оны 3 дугаар сарын 06
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал (“ЭУХ”)	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2024 оны 3 дугаар сарын 06
ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшуулын хорооны хурал (“ЗНДЦУХ”)	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> 2024 оны 3 дугаар сарын 06

1.1 ТУЗ-ИЙН ХУРЛУУД

1.1.1 ТУЗ-ийн ээлжит хурал 2024 оны 3 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

- 1 ТУЗ-ийн өмнөх шийдвэр, зөвлөмжийн талаарх явцын мэдээлэл;
- 2 ТУЗ-ийн дэргэдэх Хороодын тайлан:
 - 2.1 ЗНДЦУХ
 - 2.2 АХ
 - 2.3 ЭУХ
- 3 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн/тайлан;

- 4 ТСН-ийн хүсэлтээр ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад асуудал нэмж тусгах;
- 5 ХасБанкийг ТСН-тэй нэгтгэх, нэгтгэх гэрээ болон холбогдох зөвшөөрөл;
- 6 ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 4 дүгээр сарын 29-ний өдөр зарлан хуралдуулах тухай;
- 7 Стратегийн баримт бичиг;
- 8 Удирдлагын тайлан (2024 оны 1 дүгээр сарын байдлаар);
 - Эдийн засаг, банкны салбарын тайлан
 - Бизнесийн гүйцэтгэл
 - Санхүүгийн үр дүн
- 9 Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны ерөнхий журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- 10 СЗХ-ны бодлогын өөрчлөлт: ХасБанкны дүрэмд өөрчлөлт оруулах тухай зөвлөмж;
- 11 СЗХ-ны бодлогын өөрчлөлт: ХасБанкны ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулах тухай зөвлөмж;
- 12 Бусад.
 - Асуудал (5) ХасБанкийг ТСН-тэй нэгтгэх гэрээ дээр, тодорхой нөхцөлүүдийн талаар, миний зүгээс тодруулга авсан.
 - (2), (3), (4), (5), (7), (9), (10), (11) асуудлыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй баталсан.
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

1.1.2 ТУЗ-ийн ээлжит бус хурал

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцэв:
 1. Ногдол ашиг хуваарилах тухай;
 2. 2024 оны хагас жилийн ногдол ашгийн тухай (санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор шийдвэрлэх шаардлагын дагуу чиглэл болгох тогтоол батлах).
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
- ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал

Тайлант хугацаан дахь ТУЗ-ийн цахим санал хураалтын хурлууд

Хүснэгт 2

Хурал	Санал хураалт	Огноо
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. Эчнээ санал хураалт хэлбэрээр зохион байгуулсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үр дүнг хүлээн зөвшөөрөх тухай.	2024 оны 2 дугаар сарын 02-05
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. Банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай.	2024 оны 3 дугаар сарын 12-15

- Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

1.2 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ХУРАЛ (“АХ”)

Хүснэгт 3-т заасан дараах **АХ-ны хуралд** оролцсон.

Тайлант хугацаан дахь АХ-ны хурлууд

Хүснэгт3

Огноо	Хэлэлцсэн асуудал
2024 оны 3 дугаар сарын 06	1. ХасБанкны 2023 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан; 2. Холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах (хэлэлцэх асуудлаас хасагдсан); 3. Аудитын тайлан: 3.1 Хөрөнгө зохицуулалтын үйл ажиллагааны зайны хяналтын аргачлал 3.2 2024 оны аудит- Тайлан 1 4. Банкны холбогдох этгээдүүдийн улирлын тайлан (МонголБанкны журам).

- ТУЗ-ийн Аудитын хорооны хурлыг, Аудитын хорооны даргын хувьд миний бие удирдаж явуулсан.
 - Хурлын өмнө, зарим асуудлуудын талаар Ерөнхий аудитортой уулзалт хийн, зөвлөлдсөн.
- Асуудал (1)-ийг хорооны гишүүд санал нэгтгэйгээр баталж, ТУЗ-ийн хурал руу батлуулахаар шилжүүлсэн.
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

1.3 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ ХУРАЛ (“ЭУХ”)

Хүснэгт 4-т заасан дараах **ЭУХ-ны хуралд** оролцсон.

Тайлант хугацаан дахь ЭУХ-ны хурлууд

Хүснэгт4

Огноо	Хэлэлцсэн асуудал
2024 оны 3 дугаар сарын 06	1. ХасБанкны эрсдэлийн тайлан /2024 оны 1 дүгээр сарын байдлаарх/ 2. 2024 оны 1 дүгээр сарын байдлаарх хянан нийцүүлэлтийн явцын мэдээ/тайлан 3. Хөрвөх чадварын стресс тест ба хувилбарын дүн шинжилгээ 4. Ажилтны зээл 5. Зээлийн хяналт ба удирдлага 6. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зураглал (roadmap)

- Дээрх асуудал (3) дээр, гадаад эх үүсвэрийн нэгтгэлийн хувьд, түүний задаргааны талаар миний зүгээс тодруулга авсан.
- Асуудал (4), (6)-ийг хорооны гишүүд санал нэгтэй баталж, ТУЗ-ийн хурал руу батлуулахаар шилжүүлсэн.
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

1.4 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЫН ХОРООНЫ ХУРАЛ (“ЗНДЦУХ”)

Хүснэгт 5-т заасан дараах **ЗНДЦУХ-ны хуралд** оролцсон.

Тайлант хугацаан дахь ЗНДЦУХ-ны хурлууд

Хүснэгт 5

Огноо	Хэлэлцсэн асуудал
2024 оны 3 дугаар сарын 06	<ol style="list-style-type: none"> 1. 2023 оны гүйцэтгэл дээр суурилсан урамшууллын сан; 2. Гүйцэтгэх захирлын 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээ болон урамшуулал; 3. ТУЗ-ийн даргын 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээ болон урамшуулал; 4. Урт хугацаат урамшууллын хөтөлбөрийн бодлого; 5. Урт хугацаат урамшууллын бодлогын дагуу 2023 оны гүйцэтгэл дээр суурилсан урамшуулал; 6. ТУЗ-ийн гишүүдийн Монголбанкны зөвшөөрлийн тухай явцын мэдээлэл; 7. ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай; 8. Бусад.

- Дээрх асуудал (1) дээр, урамшууллын хуваасан сүүлийн хэсгийг олгох нөхцлийн талаар миний зүгээс тодруулга авсан.
- Дээрх асуудал (4) дээр, урт хугацаат урамшууллыг тооцоолоход хэрэглэгдэж байгаа сарын тооны талаар, миний зүгээс өөрчлөх талаар саналаа хэлж хэлэлцүүлэг өрнүүлсэн.
- Дээрх асуудал (7) дээр, задаргааны зарим зүйлийн талаар, миний зүгээс тодруулга авсан.
- Асуудал (1), (2), (3), (4), (5), (7)-ийг хорооны гишүүд санал нэгтэй баталж, ТУЗ-ийн хурал руу батлуулахаар шилжүүлсэн.
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

2. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН

(БТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг болон Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт)

БТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд, ТУЗ-ийн хурлаар сонирхлын зөрчилтэй хэлцэл батлагдаагүй.

ТУЗ-ийн гишүүдээс сонирхлын зөрчилтэй гишүүн байсан тохиолдолд тухайн гишүүн нь хурлын эхэнд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, хэлэлцсэн асуудалд санал өгөөгүй болохыг тэмдэглэж байна.

3. ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

(КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.4 дахь заалт болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг)

Дээр дурдсан хууль тогтоомжоор Хараат бус гишүүн нь Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн эсэх, мөн үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.

Банкны засаглалыг дүгнэхэд:

КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэзэгт заасан арга хэмжээ	
КтХ 79.3.1 болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.5 (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН НИЙЦЭЛ)	<p>Уг заалтын дагуу, хяналтыг тавьж зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар анхаарал тавин, бүх хурлуудад оролцож шийдвэрүүдээ гаргасан. Тайлангийн хугацаанд, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого шийдвэрүүд нь уг заалтанд тодорхойлогдохуйц сөргөөр нөлөөлсөн зүйл ажиглагдаагүй болно.</p> <p>Энэ талаар, тайлан дахь оролцсон хурал тус бүрийн тайлбарт шаардлагатай бол тэмдэглэсэн.</p>
КтХ 79.3.2 (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ)	<p>Уг заалтын хүрээнд, гүйцэтгэх удирдлага нь ил тод, нээлттэй байдлыг үргэлжлүүлэн хэвийн хангаж ажиллаж байгаа бөгөөд, тусгайчлан үүрэг өгч ажиллахаар нөхцөл байдал үүсээгүй болно.</p>
КтХ 79.3.3 (ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ)	<ul style="list-style-type: none"> Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хооронд явуулсан эчнээ санал хураалтын хурал хуралдсан.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.1 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ БАНКНЫ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН ЭСЭХ)	<p>Банкны засаглал хэвийн сайн хэрэгжиж байна.</p> <p>ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх ноцтой үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.</p>
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.2 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ)	<p>Хувь нийлүүлэгч, ТУЗ ба удирдлагын багийн хоорондох мэдээлэх процес, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу ажиллаж байна.</p>

Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.3 (БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ)	ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны харилцагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх ноцтой үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.6 (МОНГОЛБАНКИНД ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЭХ)	Тэмдэглэхүйц зүйл гараагүй.

4. БУСАД

- 2024/01/18 ХасБанкны 2023 оны 4 улирлын санхүүгийн тайлангийн цахимаар зохион байгуулагдсан танилцуулганд оролцсон.
- 2024/01/29 Банкинд санхүүжилт хийхээр судалж байгаа гадаадын хөрөнгө оруулалтын *** компанийн төлөөлөлтэй биечлэн уулзалт хийсэн.
- 2024/02/13 Урт хугацаат урамшууллын хөтөлбөрийн бодлого дээр ажиллаж байгаа гадаадын зөвлөх компанийн урьдчилсан тайлангийн цахим уулзалтанд, ЗНДЦУХ-ны ажлын хүрээнд оролцсон.
- 2024/03/11 4 сард товлогдсон хувь нийлүүлэгчдийн хуралд тавигдах Хараат бус гишүүдийн тайлангийн талаар хараат бус гишүүдтэйгээ зөвлөлдсөн.
- 2024/03 Хувь нийлүүлэгчдийн хуралд тавигдах Хараат бус гишүүдийн тайланг бэлдсэн.

Огноо: 2024/04/12

Гарын үсэг:



Б. Уламбаяр
ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн